Зүрх судасны эмгэгээс урьдчилан сэргийлэхийн тулд баримтлах 9 дүрэм

Чоннам их сургуулийн эмнэлгийн бүсийн зүрх судасны эмгэг судлалын төв

Эмчилгээний төрөл болон цаг захиалга	1899-0000	Цахим цаг захиалга	www.cnuh.com
Цусны эргэлт ба дотрын тасгийн амбулатори	062)220-6263	Зүрх судасны төв	062)220-5412
Мэдрэлийн тасгийн амбулатори	062)220-6178	Тархи судасны төв	062)220-5413
Нөхөн сэргээх, сэргээн засах тасгийн амбулатори	062)220-5198	Тархи зүрхний сэргээн засах төв	062)220-5417
Урьдчилан сэргийлэх төвийн факс	062)220-5418	Урьдчилан сэргийлэх төв	062)220-5410

Чоннам их сургуулийн ОУ-ын эмчилгээний төв

Утасны дугаар	+82-62-220-6016, 6565~6568
Цахим шуудангийн хаяг	imccnuh@gmail.com

Яаралтай тохиолдолд бүсийн кодгүйгээр
119 дугаар уруу залгаарай

전남대학교병원 지정 광주·전남 권역심뇌혈관질환센터 보건복지부 질병관리본부

*Дараах материалыг зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно

Зүрхний шигдээсийн эмнэлзүйн оношилгоо болон эмчилгээ

1. Оношилгоо

- **1-р шат – Эмчийн үзлэг,** эмчийн дүгнэлтэд үндэслэсэн шинжилгээ
- **2-р шат – Зүрхний бичлэг, цусны дэлгэрэнгүй шинжилгээ,** цээжний рентген зураг
- **3-р шат – Титэм судасны ангиографи шинжилгээ,** зүрхний хэт авиан оношилгоо, Компьютер томограф, цөмийн анагаах ухааны оношилгоо

2. Эмчилгээ

1) Цус шингэлэх судас тариа
2) Бөмбөлгөөр судас тэлэх мэс ажилбар болон Стент суулгах мэс засал

❶ Бөмбөлгөөр судас тэлэх мэс засал



Бугуй болон гуяын артерийн судсаар дамжуулан нарийссан болон бөглөрсөн титэм судсанд хүрэх бөгөөд өндөр даралт тэсвэрлэх чадвартай тусгай материалаар хийсэн бөмбөлөг хийж судас тэлэх мэс ажилбар юм.

❷ Титэм судсанд стент суулгах мэс засал



Титэм судас бөмбөлгөөр тэлэх мэс ажилбартай адилхан аргаар нарийссан болон бөглөрсөн титэм судсанд стент(тусгай металлаар хийсэн пүрш) суулгаж судсыг илүү бат бөх аргаар тэлэх арга юм. Стент нь хатуу бөгөөд тромбоз буюу цусны бүлэгнэлт үүсэхээс сэргийлж гөлгөр хэлбэртэй байдаг.

※ Бөмбөлгөөр судас тэлэх мэс засал болон Стент суулгах мэс заслын эмчилгээ нь богино хугацаанд эдгэрэх магадлал хамгийн өндөр бөгөөд эмчилгээний өртөг хямд байдаг.

(Чоннам их сургуулийн эмнэлгийн Бөмбөлгөөр судас тэлэх мэс засал болон Стент суулгах мэс заслын эмчилгээний үр дүн 98%)

3) Гол судас ба титэм судасны хооронд судас залгах мэс ажилбар – Цээжний хөндийн мэс засал

Нарийссан болон бөглөрсөн титэм судсыг орлох судас холбож зүрхэнд цусны эргэлтийг нийлүүлэх мэс засал бөгөөд Бөмбөлгөөр судас тэлэх мэс засал болон Стент суулгах мэс засал хийх боломжгүй өвчтөн ба олон титэм судас нарийссан болон бөглөрсөн тохиолдолд цээжний хөндийн мэс заслаар мэргэшсэн эмч мэргэжилтнүүд хийдэг мэс засал юм.



Эмнэлгээс гарсны дараа өдөр тутамдаа баримтлах дүрэм

- Тогтмол амбулаторийн эмчилгээ хийлгэх
- Тогтсон цагт заасан хэмжээгээр эм тариа хэрэглэх
- Эрүүл мэндэд тустай өөх тос багатай хоол идэх
- Өдөр бүр тогтмол 1 цаг дасгал хөдөлгөөн хийх
  - Хурдан алхах, хөнгөн алхах, усанд сэлэх, дугуй унах зэрэг Аэробикийн дасгал санал болгож байна
- Биеийн жинг барих
- Тамхи татдаг бол тамхины хэрэглээг багасгах
- Архины хэрэглээг багасгах
- Стресс ядаргааг хянах
  - Стресс үүсгэгч гол хүчин зүйлийг олж бодит арга хэмжээ авах, дасгал хөдөлгөөн хийх
- сонирхол хоббигоороо дамжуулан стрессээ тайлах

www.gjccvc.co.kr

심근경색증 [몽골어]

Бүсийн зүрх судасны эмгэг судлалын төв

Зүрхний шигдээсийн эмнэлзүйн оношилгоо болон эмчилгээ

전남대학교병원 CHONNAM NATIONAL UNIVERSITY HOSPITAL

Зүрхний шигдээс гэж юу вэ?


myocardial infarction

- Зүрх нь цээжний зүүн талд байрлах бөгөөд насанд хүрсэн хүний атгасан гар шиг хэмжээтэй булчингуудаас бүрдсэн эрхтэн юм.

  Зүрх нь агшиж тэлэх үйл явцаар дамжуулан хүчилтөрөгч дүүрэн цусыг бүх биеэр эргэлдүүлдэг бөгөөд 1 минутад 60 – 100 удаа агшдаг байна.

  Зүрх агших үйлдэл хийхийн тулд зүрхний булчинг тогтмол хүчилтөрөгч болон тэжээлээр хангах хэрэгтэй байдаг бөгөөд энэ үүргийг титэм судас гүйцэтгэдэг байна.
- Зүрхний шигдээс гэдэг нь атеросклероз буюу судасны хатуурлын улмаас хязгаарлалт үүсэж титэм судсанд цусны бүлэгнэлт үүсэх болон судас нарийсах зэрэг хүчин зүйлсээс хамааран хурдацтай бөглөрөх тохиолдолд зүрхэнд хүчилтөрөгч болон тэжээл нийлүүлэлт огцом буурч зүрхний булчингийн эд эс үхэх үйл явцыг хэлнэ.

Зүрхний шигдээс эмгэгийн үйл явц?

- Даралт ихсэх, Чихрийн шижин, Дислипидеми буюу цусан дахь холестеролийн хэмжээ ихсэх, тамхи татах зэрэг хүчин зүйлээс хамааран титэм судасны эндотел эс гэмтэж үрэвслийн эс болон холестерин хуримтлагдсан өөх тос судасны хамгийн дотор талын давхаргад шигдэн товруу үүссэнээр судасны хатуурал явагдана.

  Судасны хатуурал даамжирч тогтворгүй болсон товруу задарч титэм судсан дахь цусны ийлдэс идэвхэжвэл цусны цочмог бүлэгнэлт үүсэж титэм судас бөглөрдөг болно.

Тромбоз буюу цус бүлэгнэлтийн улмаас титэм судас бөглөрөх үйл явц





Титэм судасны эмгэг үүсэх үйл явц



Зүрхний шигдээсийн эрсдэлд хүчин зүйлс

Цусны даралт

Чихрийн шижин


Цусан дахь өндөр холестерин

Тамхи татах

Дасгал хөдөлгөөний дутагдал

Өөх тосны өндөр хэрэглээ

Нас


Хүйс


Гэр бүлийн өвчний түүх

Стрэсс ядаргаа

Зүрхний шигдээс эмгэгийн шинж тэмдэг

❶ Ергэлж цээжээр хөндүүрлэх
- 20 минутаас дээш хугацаагаар үргэлжлэх
- Хүчтэй ноцтой өвдөх

❷ Эрүү, мөр, хүзүү үрүү тархаж өвдөх

❸ Амьсгал боогдох
- 2Гүйсний дараа амьсгаадаж байгаа мэт шинж тэмдэг
- Амьсгалахад хэцүү болох шинж тэмдэг
- Амьсгал давчдах шинж тэмдэг

Зүрхний шигдээс эмгэгийн шинж тэмдэг илэрвэл?

- Аль болох хөдлөхгүй тайван байх хэрэгтэй
- 119 түргэн тусламж дуудаж “Бөмбөлгөөр судас тэлэх мэс ажилбар болон Стент суулгах мэс засал” хийдэг эмнэлэг үрүү явах хэрэгтэй.
- Үр дүн муутай ардын эмчилгээ болон хурууны өндөг хатгах зэрэг үйлдэл хийж цаг алдах хэрэггүй
- Шинж тэмдэг илэрснээс хойш эмнэлгийн эмчилгээ хийлгэх хүртэл хугацаа бага байх тусам өвчний урхаг бага байна. Шинж тэмдэг илэрснээс 2 цагийн дотор эмнэлэгт ирснээр зүрхний булчин үхжихээс сэргийлж чадах бөгөөд оройтлоо гэхэд 12 цагийн дотор эмнэлэгт ирвэл титэм судасны бөглөрөлийг арилгаж зүрхний булчин бүрэн үхжихээс сэргийлэх боломжтой.